

ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2023  
ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН  
ТАЙЛАН

2023.12.28

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн орон нутагт хамааралтай зорилт, арга хэмжээний хүрсэн түвшин зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлттэй харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, гарсан дүгнэлт зөвлөмжийг дараагийн шийдвэр, бодлого төлөвлөлтөд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

**ХОЁР.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан ажиллав.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд буюу [unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn) –ийн “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр” цэсэд байршсан 16 зорилтын 18 арга хэмжээнд хийлээ.

**ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН:**

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 онд хэрэгжүүлэх 4 бүлгийн хүрээнд 16 зорилтын 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр [unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn) цахим санд байршсан байна. Үүнийг бүлгээр нь харуулбал:

Эдийн засгийн бодлогын хүрээнд – 5 арга хэмжээ

Засаглалын бодлогын хүрээнд - 4 арга хэмжээ

Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд – 3 арга хэмжээ

Орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд – 6 арга хэмжээ, нийт 18 арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнаж байна.

ДУНДГОВЬ АЙМАГ


Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтийг нэгтгэн, Засгийн газрын 2020 оны 12 сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор баталсан “**БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ**”-ын 6.2.2, 6.2.3-т заасан аргачлалын дагуу арга хэмжээ болон зорилтыг үнэлж үзэхэд 16 зорилтын 18 арга хэмжээний биелэлт 94,4 хувьтай байгаа нь эхний хагас жилийн биелэлтээс 20 хувиар өссөн байна.

2022 оны жилийн эцсийн хэрэгжилттэй харьцуулахад 6.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН  
2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО


№	Агуулга	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Үнэлгээ						Хувь
				100 хувь	90 хувь	70 хувь	50 хувь	30 хувь	0 хувь	
1	Эдийн засгийн бодлого	5	5	3	1	-	1	-	-	88
2	Засаглалын бодлого	2	4	4	-	-	-	-	-	100
3	Ногоон хөгжлийн бодлого	3	3	3	-	-	-	-	-	100
4	Орон нутгийн хөгжлийн бодлого	6	6	4	1	1	-	-	-	93,3
<b>Дүн</b>		<b>16</b>	<b>18</b>	<b>14</b>	<b>2</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>94,4</b>

ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН  
СҮҮЛИЙН 3 ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАРЬЦУУЛАЛТ



Эрчимжүүлэх шаардлагатай буюу удаашралтай хэрэгжиж байгаа зорилт арга хэмжээний шалтгааныг харуулбал:

Эрчимжүүлэх шаардлагатай 2 арга хэмжээ байгаа нь хөрөнгөнөөс болон хугацааны хувьд удаашралтай байна.




**ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ 2023 ОНД /ХҮСНЭГТЭЭР/**

№	Хамрах хүрээ	Эх үүсвэр				Дүн /сая.төг/
		УТХО	ОНТ	Хувийн хэвшил	Төсөл хөтөлбөр	
1	Эдийн засгийн бодлого	99,4	30,4	-	79,9	209,7
2	Засаглалын бодлого	-	6,3	-	-	6,3
3	Ногоон хөгжлийн бодлого	-	40,0	1063,0	-	1103,0
4	Орон нутгийн хөгжлийн бодлого	422,6	699,6	96,0	4600,0	5818,2
		522,0	776,3	1159,0	4679,9	7137,2

2023 ОНД ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАСАН АЖЛУУДААС ДУРДВАЛ:

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулна.

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын шаардлагатай 300 сая төгрөгийн хөрөнгийг орон нутгийн төсөвт тусгуулан “Вектор мэл” ХХК-тай гэрээ байгуулан 14 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан, сумдад хүлээлгэн өгч төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан цогц байдлаар гүйцэтгэж аймаг, сумдын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан. Гүйцэтгэгч “Вектор мэл” ХХК 15 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг ном байдлаар эмхэтгэж гардууллаа.



Цаг агаарын гэнэтийн аюулт үзэгдлээс амжиж анхааруулах орон нутгийн дэд тогтолцоог дэмжин хөгжүүлэх говь, хээрийн бүсэд аюулаас сэрэмжлүүлэн анхааруулах 17 цогцолбор байгуулна.

Дундговь аймгийн хэмжээнд аймгийн төв болон баруун, зүүн сумдад АСА /Аюулаас сэрэмжлүүлэн анхааруулах/ 3 цогцолборыг байгуулан ажиллаж байна.

Уг АСА цогцолбороор алслагдсан сумдын малчид иргэдийг цаг агаарын аюултай үзэгдлээс урьдчилан сэргийлж, УЦУОШ төвөөс Цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээ ирсэн даруйд 14 сумдын толгой сэргийлэгч малчдад дамжуулан, сэрэмжлүүлэх мэдээг эфирээр 15-40 минутын зайтай цацаж, жилд дунджаар 60,5 мянган малчдад 24 удаагийн урьдчилан сэргийлэх мэдээг хүргэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна.

Хариуцсан ажилтантай болсонтой холбоотойгоор FM107.5 эфирийг ажиллуулахаас гадна Дундговь АСА цогцолбор нэртэй фэйсбүүк аккаунтыг нээж, малчид, ард иргэдийг олон талын хэрэгцээт мэдээллээр хангаад зогсохгүй, АСА цогцолбороор мэдээлэл хийх төрийн байгууллагуудын мэдээллийн гүйцэтгэлд хяналт тавьж аккаунтаараа шууд лайвыг давхар хийн тогтсон цагт мэдээллийг хүргэж байна.


Сүүлийн 4 жил толгойн сэргийлэх 15 малчин өрхийн утасны эрхийг жилийн хугацаатай нийт 20,1 сая төгрөгөөр сэргээсэн.





Аймаг, нийслэлийн орон нутгийн хамгаалалтын төлөвлөлтийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавина.

Аймгийн “Орон нутгийн цэргийн бэлтгэлийг хангах, байгуулах” төлөвлөгөөг шинэчлэн, хавсралт тооцоог боловсруулж, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргаар батлуулан хэрэгжилтийг 100 хувь зохион байгуулж ажилласан. Монгол Улсын “Орон нутгийн хамгаалалтын тухай” хуулийн дагуу орон нутгийн хамгаалалтын удирдах бүрэлдэхүүн бусад албан тушаалтнуудтай сургалтыг төлөвлөгөөний дагуу цахимаар зохион байгуулж, томилогдсон үүргээ биелүүлэх, чадвар эзэмшүүлсэн. Аймаг, нийслэлийн орон нутгийн хамгаалалтын төлөвлөлтийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих ажлыг жил бүр хугацаанд нь боловсруулан батлуулж ажиллаж байна. 2023 оны цэргийн бүртгэлийн үеэр сумдын орон нутгийн хамгаалалтын отрядын бүрэлдэхүүний томилгоожуулан даалгаваржуулсан. Цэргийн штабын 2023 оны цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу сургалтыг Сайхан-Овоо, Сайнцагаан, Гурвансайхан, Дэлгэрхангай сумдад 44 хүнтэйгээр орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн сургалтыг хийсэн.



Орон нутгийн хамгаалалтын сургалтын тогтолцоог бүрдүүлэх, томилгоот нэгжийн үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангана.

Сумдад 2023 оны 10.01-10.05-ны өдрүүдэд аймгийн Цэргийн штабын “Сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний дагуу орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн сургалтыг Сайнцагаан Өлзийт, Дэлгэрхангай Сайхан-Овоо зэрэг сумдын орон нутгийн хамгаалалтын сургалтыг зохион байгуулж онол, дадлагын бэлтгэл, үүрэг гүйцэтгэх бэлэн байдлын зэргийг дээшлүүлсэн. Жил бүр сургалтын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын захирамжаар батлуулан сургалтыг зохион байгуулж байна.





Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, гол мөрний болон хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах, усан сан, хөв, цөөрөм байгуулна.

Орхон голоос эх авч Онги голын урсцыг нэмэгдүүлэх зорилготой “Орхон-Онги” эко төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан. Жил бүр булаг”-ийн эхийг хашиж хамгаалах ажлыг 2-3-ыг гүйцэтгэж байна. 2023 онд 4 газарт булгийн эхийг хашиж хамгаалсан ба аймгийн хэмжээнд нийт 63 булгийн эхийг хамгаалаад байна. Тус ажлыг гүйцэтгэхэд БХНСАХ Зардлаас 15 сая.төгрөг, орон нутгаас 60,5 сая.төгрөг, хувийн хэвшлийн 6.0 сая.төгрөг нийт 81,5 сая төгрөг зарцуулав. Дундговь аймгийн Өлзийт сумын Буянт багийн нутаг “Жавхлант хайрхан” хэмээх газарт байрлах “Хөтөл ус”-ны энгийн уурхайн худгийг түшиглэн хөв цөөрөм байгуулах ажлыг “Хангда” ХХК-ны гүйцэтгэлээ. Тус ажлыг зураг төсвийн дагуу 1 метрийн голчтой 3 ширхэг кольцо суулгаж, 120 мм диаметртай, 42 метрийн урттай ус дамжуулах хуванцар хоолой суурилуулж, 4 м3 эзлэхүүнтэй усан сан барьсан. “Хөтөл ус”-ны хөв цөөрмөөс 120 гаруй янгир, 100 гаруй аргаль, 60 гаруй бор гөрөөс, 12 өрхийн 8000 гаруй мал ундаална. Мөн Юнител группийн хөрөнгө оруулалтаар "Дэлгэрхангай уул", "Их газрын чулуу" улсын тусгай хамгаалалттай газруудад тус бүр 1 зэрлэг амьтдад зориулсан хөв цөөрмийг байгуулав. Нийт 3 хөв цөөрөм байгуулав.



## ДУНДГОВЬ АЙМАГ



Бат-Өлзийн Бат-Эрдэнэ · Дагах  
2023.05.09 · 🌐



🇮🇸 ХӨВ ЦӨӨРӨМ БАЙГУУЛАХ АЖЛЫГ УЛС ОРОН ДАЯАР ЯВУУЛНА.

Хөв цөөрөм хийх газрын судалгаа, хянан баталгаажуулалтын ажлаар Усны зөвлөх инженер Л.Түвд болон Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргааны дарга, мэргэжилтнүүдийн хамтарсан ажлын хэсэг 2023 оны 05 сарын 03-ний өдрөөс эхлэн Жаргалан, Баян-Уул, Дарив, Шарга сумдад ажиллалаа.

Тус ажлын хүрээнд:  
С... Цааш үзэх



Хөдөө орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих дэд бүтцийг бий болгон бизнес эрхлэх нэн таатай орчныг бий болгоно.

Зах зээл ба бэлчээрийн эрсдэлийн удирдлага төслийн 382,3 сая төгрөгийн санхүүжилтээр орон нутгийн бүтээгдэхүүнийг худалдан борлуулах цэг шинээр баригдлаа. Цэгтэй болсноор орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээс шимтгэл авахгүйгээр үйлдвэрлэгчээс ирүүлсэн үнээр борлуулагдах зах зээлийг тэлэх боломжийг бүрдүүлсэн.

Бизнес хөгжлийн төвийг шинээр ашиглалтад оруулж 20 үйлдвэрлэл эрхлэгч иргэдийг түрээсийн төлбөргүйгээр ашиглах боломжоор ханган үйл ажиллагааг дэмжин сурталчилж байна.

“Дундговьд үйлдвэрлэл” дэлгүүрт 170 иргэн, ААНэгжийн 30 нэр төрлийн бүтээгдэхүүн 164,0 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж байна. Дундговь түншлэл-2020 үзэсгэлэн худалдаанд 14 сумын 94 үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нар оролцсон.

Бизнес эрхлэгч нар нийт 33,0 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан. Дундговьд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ худалдан борлуулах албан ёсны 3 цэг ажиллаж байна.

ХҮҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НИЛ

## ДУНДГОВЬД ҮЙЛДВЭРЛЭВ ХУДАЛДААНЫ ТӨВ

48 өрх

26 нэр төрөл

100 сая төгрөг



Дундговь аймаг Засаг даргын Тамгын газар

6-р сарын 22 · 🌐



### "БИЗНЕСИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТӨВ" НЭЭЛТЭЭ ХИЙЛЭЭ

Дундговь аймагт үйлдвэрлэл, үйлчилгээ, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх, цаашид тууштай үйл ажиллагаа явуулж хөгжих боломж нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хуучин МСҮТ-ийн барилгад их засвар хийж, түрээс төлбөргүйгээр, ашиглалтын зардлыг хариуцуулан ашиглуулах "Бизнес хөгжлийг дэмжих төв" өнөөдөр буюу 06-р сарын 22-ны өдөр нээлтээ хийлээ.

Тус төвд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй 15 бизнес эрхлэгч үй... Цааш үзэх



Гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлнэ.



2023 онд стандартын шаардлага хангахгүй 24 нүхэн жорлонг буулгаж, шинээр 109 ариун цэврийн байгууламж нэмэгдэж, аймгийн хэмжээнд стандартын шаардлага



хангасан ариун цэврийн байгууламжийн тоо 65 байсан нь 174 -д хүрэв. Жил бүр үе шаттайгаар айл өрхүүд, аж ахуй нэгжийн нүхэн жорлонг стандартын шаардлагад нийцүүлэн сольж, сайжруулах ажил хийгдэж байна.

Аймгийн төвөөс алслагдсан сумдад ажиллаж, амьдарч байгаа эрүүл мэнд, боловсрол, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагын албан хаагчдын ажиллаж, амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх хүрээнд албаны орон сууцаар хангах ажлыг зохион байгуулна.

Аймгийн төвөөс алслагдсан сумдад ажиллаж, амьдарч байгаа 11 эмч, 128 багш нарыг албаны орон сууцаар хангаж, 4 онцгой байдлын аврагчдыг байшин барих газрыг шийдвэрлэн, аймгийн Хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд 19 эмч, багш нарт 153 сая төгрөгийн орон сууцны дэмжлэг үзүүлж, орон сууцаар хангагдсан албан хаагчдын эзлэх хувь 47%-тай болж, өмнөх жилээс 4.5 хувиар өссөн.



## ДУГНЭЛТ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс аймагт хамааралтай 2023 онд тайлагнах 16 зорилтын 18 арга хэмжээг ЗГХЭГ-ын [unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn) цахим программаар тайлагналаа.

16 зорилтын 18 арга хэмжээг Засгийн газрын 2020 оны 12 сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын 6.2.2-т заасны дагуу 2023 оны хэрэгжилтийг үнэлэхэд 18 арга хэмжээний дундаж 94,4 хувьтай хэрэгжсэн байгаа нь эхний хагас жилээс 20 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2023 оны эхний хагас жилийн байдлаар удаашралтай хэрэгжиж арга хэмжээнүүдийг эрчимжүүлэхээр холбогдох хэлтэс, агентлагт очиж явцын хяналт-шинжилгээ хийж зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулж, Засаг даргын сонголт мэдээллийг зохион байгуулан, холбогдох агентлагууд хуваарийн дагуу Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй ажлаа танилцуулж, цаашид анхаарч ажиллах талаар аймгийн удирдлагууд үүрэг чиглэлийг өгч ажилласан нь үр дүнгээ өгч хэрэгжилтийн хувь нэмэгдсэн.



**СОНСГОЛ МЭДЭЭЛЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА**

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн удаашралтай хэрэгжиж буй заалт, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг хэлэлцэн хэрэгжилтийн бодит үр дүнг нэмэгдүүлэх, бодлогын хэлтэс, агентлаг хоорондын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс зохион байгуулж, аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат болон хэлтэс, аг... **Цааш үзэх**



**Томоохон хөрөнгө оруулалт шаардлагатай, бүтээн байгуулалтын 3 арга хэмжээ байгаа нь удаан жил үргэлжлэх арга хэмжээ байна.**

1. Аймгийн төвүүдэд үерийн хамгаалалтын барилга, байгууламж барих ажлыг үе шаттай хэрэгжүүлэх ажил 6,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 7,68 км үерийн хамгаалалтын далан суваг барих ажлын 1,2 км -ыг УТХО-ын 1,4 тэрбум төгрөгөөр гүйцэтгэж, цаашид хийгдэх ажлын 5,1 тэрбум төгрөгийн хөрөнгийн асуудлыг жил бүр улсын төсөвт тусгуулахаар хүсэлт өгч шийдвэрлэх боломжгүй зогссон.

2. Инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг сайжруулах замаар аймаг бүрд гэр хорооллын 600-аас доошгүй өрхийг инженерийн хангамжид холбож, орон сууцны нөхцөлийг сайжруулах хүрээнд аймгийн 15 сумын 4 суманд 100 хувь хийгдэж, 3 сум 75 хувьтай хийгдэж байна. Аймгийн 7 сумын усан хангамж, ариутгах татуургын ажлыг гүйцэтгэхэд 20 тэрбум 733 сая төгрөг зарцуулсан байна. Усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон 4 сумын 3296 гэр хорооллын өрхөөс хувийн орон сууцтай 2181 өрх байгаагийн 414 өрх цэвэр болон бохирын системд холбогдоод байна. Аймгийн 4 сумын усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээгээр хангагдсан гэр хорооллын өрхийн 19 хувийг эзэлж байгаа бөгөөд сүүлийн 3 жилд 13 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Дэлхийн банкны 4,6 тэрбум төгрөгийн хөрөнгөөр аймгийн төвийн 0,4кв-ын хуваарилах сүлжээг 100 хувь шинэчлэх, хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний тоолуурыг ухаалаг тоолуураар солих ажлыг “Проект ватт” ХХК гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.

3. Аймаг, сумын төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж, хог боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулах арга хэмжээний хүрээнд дахивар хог авах "Баялаг төв" шинээр нээгдсэн ба нийт 143.5 тонн хог хаягдлыг ангилан ялгаж, үүнээс 63.95 тонн дахин ашиглах, 79.45 тонн дахин боловсруулах үйлдвэрт тушааж 0.1 тонныг сэргээн ашигласан байна. 10 сум 77,5 га талбайг шууж булшилсан. Аймгийн хэмжээнд дахивар цуглуулах 7 цэгтэй болсноор нийт 81 тонн дахивар цуглуулсан. Үүнээс дахин боловсруулах үйлдвэрт 40 тонн дахивар нөөц тушаасан үзүүлэлттэй байгаа бөгөөд дахин боловсруулах томоохон үйлдвэр барих ажилд ихээхэн хэмжээний хөрөнгө шаардлагатай байна.

***Эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлого боловсруулж, шийдвэр гаргах зохион байгуулалтын шинж чанартай 15 арга хэмжээ байна. Үүнээс:***

Бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан татварын шаталсан тогтолцоог хөгжүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжих арга хэмжээний хүрээнд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн шууд захирагч нар ЖДҮД сан, Хоршоо хөгжүүлэх сан, ХЭД сангийн хөнгөлөлттэй зээлд хамруулах, газрын асуудлыг шийдвэрлэх зэрэг дэмжлэг үзүүлж байна. Татварын ерөнхий хууль бусад хуулийн хүрээнд хэрэгждэг хөнгөлөлт, дэмжлэгийг баримтлан ажиллаж байна.

ДУНДГОВЬ АЙМАГ

2020-2023 ОНЫ ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭНД ХАРЬЦУУЛАЛТ ХИЙЖ  
ХАРУУЛБАЛ:

№	Хөрөнгө оруулалтын нэр төрөл	Дүн /сая.төг/				
		2020 он	2021 он	2022 он	2023 он	2020-2023
1	Улсын төсвийн хөрөнгө	10391,3	3821,9	7287,0	522,0	22022,2
2	Орон нутгийн төсөв	355,9	944,9	1202,1	776,3	3279,2
3	Хувийн хэвшил, хандив тусламж	434,8	486,5	118,3	1159,0	2198,6
4	Төсөл хөтөлбөр	-	682,3	-	4679,9	5362,2
		11182,0	5935,6	8607,4	7137,2	32862,2

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг 2023 онд хэрэгжүүлэхэд нийт 7 тэрбум 137,2 сая төгрөг зарцуулсан бөгөөд гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлсэн санхүүжилтийн хэмжээ хамгийн өндөр буюу 65,5 хувийг эзэлж байна. Хувийн хэвшил, хандив тусламж болон Төсөл хөтөлбөрөөр 5838,9 хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт 81,8 хувийг, Улсын төсвийн хөрөнгөөр 7,3 хувийг, Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10,8 хувийг санхүүжүүлсэн байна.

2020-2023 оны хөрөнгө оруулалт хэмжээ 32 тэрбум 862,2 сая төгрөг бөгөөд улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ өндөр ба 67 хувийг эзэлж байна. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гадаадын зээл тусламж болон хувийн хэвшлийн хөрөнгө, хандив тусламжаар хийгдсэн хөрөнгө оруулалт 23 хувь байна.





ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Улсын түвшинд:

1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнах, unelgee.gov.mn программын гүйцэтгэл оруулах талбарыг богино хугацаанд нээгээд, баталгаажуулж хаагдах нь ажлын ачааллыг ихэсгэж байгаа тул урт хугацаанд нээх нь программд хэрэгжсэн гүйцэтгэлээ нотлох баримтын хамт шивж, гүйцэтгэлээ хянах, анализ хийхэд ихээхэн ач холбогдолтой байна.
2. Бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан татварын шаталсан тогтолцоог хөгжүүлэх арга хэмжээ нь орон нутгийн түвшинд шийдвэрлэх боломжгүй ба дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжүүлж байна. Энэ арга хэмжээний хувьд хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх улсын хэмжээний ажил юм гэсэн саналтай.

Аймгийн түвшинд:

1. Хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлсэн нотлох баримтыг аль болох судалгаанд үндэслэн график, диаграммаар илэрхийлэх
2. Арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг бодитой, үнэн зөв тайлагнах
3. Хэрэгжилтийн үр дүнг тоо баримтаар тодорхой илэрхийлж тайлагнах

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА

Д.ДААРИЙМАА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Н.ДЭЛГЭРМАА